

Сангийн сайдын 2018 оны  
12 дугаар сарын 25-ны өдрийн  
295 тоот тушаалын 2 дугаар хавсралт

## УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТӨСЛИЙГ ДАХИН ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

/Аргачлал – 1/

### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Төсвийн хөрөнгө оруулалтыг зохистой удирдах, үр өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй бүх төслийг /цаашид “төсөл” гэх/ дахин үнэлэхэд энэхүү аргачлалыг баримтална.
- 1.2. Төслийг дахин үнэлэх үйл ажиллагаа нь дараах 3 үе шаттай байна. Үүнд:
  - 1.2.1. төслийг ангилах;
  - 1.2.2. төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах;
  - 1.2.3. төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хянах, шийдвэрлэх.
- 1.3. Энэхүү аргачлалыг Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын систем (цаашид “Цахим систем” гэх)-д суурилан хэрэгжүүлнэ.
- 1.4. Цахим системийн “Шилжих төслүүдийг үнэлэх” цэсийг сонгож ажиллах ба дахин үнэлгээнд шаардагдах мэдээллийг оруулж, үнэлгээг хийнэ.

### Хоёр. Төслийг ангилах

- 2.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэхүү аргачлалд заасны дагуу хэрэгжиж буй бүх төслүүдийг үнэлж, дараах байдлаар ангилна. Үүнд:
  - 2.1.1. эргэлзээтэй буюу дахин үнэлэх шаардлагатай;
  - 2.1.2. хэвийн буюу үргэлжлүүлэх.
- 2.2. Төслийг дахин үнэлэхдээ санхүүжилтийн хүндрэл болон хэрэгжилт хангалтгүй гэсэн ерөнхий үзүүлэлтэд хамаарах 3 шалгуур үзүүлэлтийг ашиглаж, дараах байдлаар ангилна. Үүнд:
  - 2.2.1. Төслийн санхүүжилтийн хүндрэлийг тогтооход төсөвт өртөг нэмэгдсэн, эсхүл санхүүжилт удааширсан эсэхийг тодорхойлж дараах байдлаар шалгана:
    - 1) Төсөвт өртгийн нэмэгдэл: Төслийн санхүүжилтийн гүйцэтгэл болон нэмж шаардагдах санхүүжилтийн нийт дүн нь анхны төсөвт өртгөөс хэтэрсэн;
    - 2) Санхүүжилтийн хүндрэл: Сүүлийн хоёр жилийн нийт санхүүжилт нь төсөвт өртгийн 20 буюу түүнээс бага хувьтай байсан;
  - 2.2.2. Төслийн хэрэгжилт хангалтгүй байгааг тогтооход төслийн хэрэгжилт удааширсан эсэхийг дараах байдлаар шалгана:
    - 1) Хэрэгжилт удааширсан: Төслийн хэрэгжиж дуусах хугацаа нь анх төлөвлөсөн хугацаанаас нэгээс дээш жилээр хэтрэх тохиолдолд;

(Төслийг дахин үнэлж, шалгах ажиллагааг хүснэгтээр харуулав.)

Ангилал	Шалгуур үзүүлэлт	Томьёо
Санхүүжилтийн хүндрэл	1) <u>Төсөвт өртгийн нэмэгдэл</u> : Санхүүжилтийн гүйцэтгэл (СГ) болон нэмж шаардагдах санхүүжилт (НС) -ийн нийт дүн нь анхны төсөвт өртөг (ТӨ)-өөс хэтэрсэн;	$\frac{СГ + НС}{ТӨ} > 1$

	<u>2) Санхүүжилтийн хүндрэл:</u> Сүүлийн хоёр жилийн нийт санхүүжилт (С2ЖНС) нь төсөвт өртөг (ТӨ)-ийн 20 буюу түүнээс бага хувь ;	$C2ЖНС/ТӨ \leq 20\%$
Хэрэгжилт хангалтгүй	<u>3) Хэрэгжилт удааширсан:</u> Төслийн хэрэгжиж дуусах хугацаа нь (ТХэ) анх төлөвлөсөн хугацаанаас (ТХу)-аас нэгээс дээш жилээр хэтрэх тохиолдолд;	$ТХэ - ТХу > 1 \text{ жил}$

- 2.3. Төсөл нь Аргачлалын 2.2-т заасан 3 шалгуур үзүүлэлтийн аль нэгд хамрагдсан тохиолдолд тухайн төслийг эргэлзээтэй буюу дахин үнэлэх шаардлагатай төслийн ангилалд оруулах бөгөөд төслийг цаашид хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулна.
- 2.4. Төсөл нь Аргачлалын 2.2-т заасан 3 шалгуур үзүүлэлтийн аль нэгд хамрагдаагүй тохиолдолд хэвийн буюу үргэлжлүүлэх төслийн ангилалд оруулах бөгөөд тухайн төслийг төсөвт тусгах үндэслэл болно.
- 2.5. Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэхүү аргачлалын дагуу төслүүдийг ангилж, төсөвт үргэлжлүүлэн тусгах хэвийн төслүүдийн жагсаалт болон эргэлзээтэй ангилалд оруулсан төслийг өөрчлөн хэрэгжүүлэх хувилбарын саналаа 08 дугаар сарын 15-ны дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид "Сангийн яам" гэх/-ын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.
- 2.6. Төсвийн ерөнхийлөн захирагч нь эргэлзээтэй ангилалд орсон дараах төслийг үргэлжлүүлэн төсөвт тусгах саналаа Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлж болно. Үүнд:
- 2.6.1. олон улсын гэрээгээр болон бусад гэрээгээр зайлшгүй хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн төсөл;
- 2.6.2. төслийн ажлын гүйцэтгэл 80-аас дээш хувьтай;
- 2.6.3. төслийн санхүүжилтийн гүйцэтгэл 80-аас дээш хувьтай;

### **Гурав. Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах**

- 3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэхүү Аргачлалын 2 дах бүлэгт заасан ангиллын дагуу эргэлзээтэй ангилалд орсон төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг дараах хувилбараар боловсруулна. Үүнд:
- 3.1.1. Төслийг шинэчлэн хэрэгжүүлэх: энэ хувилбарыг төслийн хүчин чадал, эсхүл зориулалтыг өөрчлөх тохиолдолд сонгоно.
- 3.1.2. Төслийг хойшлуулах: төслийг нэг болон түүнээс дээш жилээр хойшлуулахад ач холбогдол нь хэвээр хадгалагдах болон нэмэгдэх тохиолдолд энэ хувилбарыг сонгоно.
- 3.1.3. Төслийг зогсоох, дуудлагаар худалдах: энэхүү аргачлалын 3.1.1 болон 3.1.2-т заасан хувилбарт хамрагдаагүй тохиолдолд төслийг зогсоож, дуусаагүй барилга байгууламж, хөрөнгийг хуульд заасны дагуу дуудлагаар худалдана.
- 3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төслийг өөрчлөх хувилбар бүрт түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарын авлагад заасан маягтуудын дагуу боловсруулж, Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.
- 3.3. Энэхүү аргачлалын 3.1.1-д заасны дагуу төслийг шинэчлэн хэрэгжүүлэх тохиолдолд тухайн төслийг шинэ төсөлд тооцож, холбогдох аргачлалын дагуу үнэлгээ хийнэ.

## **Дөрөв. Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хянах, шийдвэрлэх**

- 4.1. Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь Төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлсэн шилжиж буй төслийн ангилал, төслийг өөрчлөн хэрэгжүүлэх төлөвлөгөөний саналыг үндэслэн холбогдох журамд заасны дагуу шийдвэрийг гаргана.